**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГСА-2024/22/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Говьсүмбэр аймаг<br>2024 он | Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа<br>Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn<br>Аудитын менежер: Г.Наранбаяр<br>Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn<br>Аудитор: С.Батцэцэг<br>Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт**

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2024.03.23 № 33
танай ______________-ны № ______________-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
О.БАЙГАЛЬСАЙХАН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Нийгмийн даатгалын сангийн түр дансанд төвлөрсөн орлогоос санхүүгийн тайланд тусгагдаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй өр төлбөрийг шилжүүлж, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, НББ тайлагналд өмнөх үеийн үр дүн дансанд бичилт хийж, цэвэр хөрөнгө, эздийн өмчийн тайланд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансыг үндэслэлгүйгээр бууруулж буруу илэрхийлсэн, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй өр, авлагыг тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.6, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

0008020109

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

НДЕГ-ын даргаар батлуулсан байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлж 85 хувь гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,446,721,682.90** | **11,888,054,559.83** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **2,610,794,676.49** | **3,217,401,751.13** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **2,610,794,676.49** | **3,217,401,751.13** |
| **31210** | **Төгрөг** | **2,610,794,676.49** | **3,217,401,751.13** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 4,245,840.91 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 2,610,794,676.49 | 3,213,155,910.22 |
| **33** | **АВЛАГА** | **7,831,933,656.41** | **8,662,089,158.70** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2.00 | 2.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 6,479,125,439.94 | 8,185,920,510.33 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 1,326,846,547.26 | 456,423,927.15 |
| **33500** | **Бусад авлага** | **25,961,667.21** | **19,744,719.22** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 25,961,667.21 | 19,744,719.22 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **3,993,350.00** | **8,563,650.00** |
| **35400** | **Хангамжийн материал** | **3,993,350.00** | **8,563,650.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 75,000.00 | 2,210,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,445,350.00 | 4,312,650.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 473,000.00 | 1,594,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.00 | 300,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 0.00 | 147,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **779,422,296.36** | **748,329,447.51** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **779,422,296.36** | **748,329,447.51** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **755,353,296.36** | **724,260,447.51** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 812,475,675.68 | 812,475,675.68 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -117,469,104.72 | -132,779,669.88 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 41,000,000.00 | 41,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -41,000,000.00 | -41,000,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 56,781,851.38 | 58,281,851.38 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -10,977,701.00 | -22,889,252.97 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 57,530,270.00 | 55,829,230.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -42,987,694.98 | -46,657,386.70 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **24,069,000.00** | **24,069,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 24,069,000.00 | 24,069,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **11,226,143,979.26** | **12,636,384,007.34** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **62,656,169.47** | **181,092,062.50** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **62,656,169.47** | **181,092,062.50** |
| **41300** | **Өглөг** | **33,054,271.82** | **58,406,909.43** |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 33,054,271.82 | 58,406,909.43 |
| **41400** | **Урьдчилж орсон орлого** | **29,601,897.65** | **122,685,153.07** |

| | | | |
|---|---|---|---|
| 41410 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 29,601,897.65 | 122,685,153.07 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **11,163,487,809.79** | **12,455,291,944.84** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **11,163,487,809.79** | **12,455,291,944.84** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 150,010,138.98 | 150,010,138.98 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 150,010,138.98 | 150,010,138.98 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **10,905,998,532.76** | **12,197,802,667.81** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 11,990,701,956.74 | 10,898,024,529.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -1,084,703,423.98 | 1,299,778,138.06 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 107,479,138.05 | 107,479,138.05 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **11,226,143,979.26** | **12,636,384,007.34** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **25,812,037,343.23** | **31,018,911,272.25** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **17,808,499,482.13** | **22,760,194,907.68** |
| **112** | **Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого** | **17,808,499,482.13** | **22,760,194,907.68** |
| 112001 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 12,085,183,435.68 | 15,491,505,370.86 |
| 112002 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,276,311,795.12 | 1,636,679,529.26 |
| 112003 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,348,362,188.92 | 1,688,127,679.35 |
| 112004 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 256,214,411.24 | 326,090,782.88 |
| 112005 | Эрүүл мэндийн даатгалын шимтгэл | 2,842,427,651.17 | 3,617,791,545.33 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **11,613,690.10** | **56,487,026.42** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **11,613,690.10** | **56,487,026.42** |
| 120002 | Хүүгийн орлого | 0.00 | 44,128,581.41 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **2,050,628.10** | **4,396,889.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,015,242.00 | 4,396,889.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,386.10 | 0.00 |
| 120009 | Бусад орлого | 9,563,062.00 | 6,851,505.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 0.00 | 1,110,051.01 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **7,991,924,171.00** | **8,202,229,338.15** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,982,801,801.00** | **2,392,517,883.56** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,982,801,801.00 | 2,392,517,883.56 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0.00** | **4,572,293.59** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 4,572,293.59 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **5,697,726,170.00** | **5,238,606,261.00** |
| 133002 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,697,726,170.00 | 5,238,606,261.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **311,396,200.00** | **566,532,900.00** |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 305,597,200.00 | 566,532,900.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 5,799,000.00 | 0.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **26,896,740,767.21** | **29,719,133,134.19** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **26,896,740,767.21** | **29,719,133,134.19** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **336,447,123.56** | **483,152,146.92** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **210,980,255.54** | **323,815,386.66** |
| 210101 | Үндсэн цалин | 134,996,818.09 | 199,930,109.39 |
| 210102 | Нэмэгдэл | 43,127,744.45 | 70,684,275.09 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,540,000.00 | 20,113,098.44 |
| 210104 | Урамшуулал | 16,315,693.00 | 33,087,903.74 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **27,289,537.36** | **39,667,320.92** |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,879,470.49 | 27,164,576.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,108,816.64 | 3,195,832.55 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,680,333.31 | 2,556,665.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 420,083.33 | 611,153.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,200,833.59 | 6,139,092.45 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **46,468,897.00** | **46,769,881.38** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,289,993.00 | 3,074,097.38 |
| 210302 | Түлш, халаалт | 42,922,524.00 | 41,845,792.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,256,380.00 | 1,849,992.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **15,553,058.00** | **25,141,959.10** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,299,000.00 | 5,003,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,559,000.00 | 1,587,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,255,000.00 | 2,247,608.10 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 170,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,260,058.00 | 16,134,351.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,871,000.00** | **6,998,200.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 924,000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 947,000.00 | 6,998,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **438,000.00** | **3,402,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 438,000.00 | 3,402,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,617,730.00** | **4,229,499.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,800,000.00 | 2,379,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 797,100.00 | 797,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 65,300.00 | 99,882.00 |
| 210807 | Газрын төлбөр | 0.00 | 24,957.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,005,730.00 | 928,060.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 949,600.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **29,228,645.66** | **33,127,899.86** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 950,000.00 | 925,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 28,278,645.66 | 32,202,899.86 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **26,560,293,643.65** | **29,235,980,987.27** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **19,150,440,087.00** | **22,723,343,810.56** |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 19,146,465,087.00 | 22,708,142,510.56 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,975,000.00 | 3,163,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 12,038,300.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **7,409,853,556.65** | **6,512,637,176.71** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,409,853,556.65 | 6,512,637,176.71 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-1,084,703,423.98** | **1,299,778,138.06** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-1,084,703,423.98** | **1,299,778,138.06** |

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **150,010,138.98** | **107,479,138.05** | **11,990,701,956.73** | **12,248,191,233.76** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **0.01** | **0.01** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **150,010,138.98** | **107,479,138.05** | **11,990,701,956.74** | **12,248,191,233.77** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **-1,084,703,423.98** | **-1,084,703,423.98** |
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **150,010,138.98** | **107,479,138.05** | **10,905,998,532.76** | **11,163,487,809.79** |
| **11** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **150,010,138.98** | **107,479,138.05** | **10,905,998,532.76** | **11,163,487,809.79** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -7,974,003.01 | -7,974,003.01 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **150,010,138.98** | **107,479,138.05** | **10,898,024,529.75** | **11,155,513,806.78** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 1,299,778,138.06 | 1,299,778,138.06 |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **150,010,138.98** | **107,479,138.05** | **12,197,802,667.81** | **12,455,291,944.84** |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **25,582,724,194.67** | **30,320,205,781.77** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **17,404,553,070.61** | **21,088,727,956.37** |
| **112** | **Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого** | **17,404,553,070.61** | **21,088,727,956.37** |
| 112001 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 11,811,615,797.96 | 14,354,251,401.61 |
| 112002 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,247,758,879.69 | 1,515,486,706.37 |
| 112003 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,316,628,465.68 | 1,562,599,998.87 |
| 112004 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 250,609,665.53 | 302,349,676.91 |
| 112005 | Эрүүл мэндийн даатгалын шимтгэл | 2,777,940,261.75 | 3,354,040,172.61 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **163,582,024.06** | **101,053,570.81** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **163,582,024.06** | **101,053,570.81** |
| 120002 | Хүүгийн орлого | 0.00 | 44,128,581.41 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **163,582,024.06** | **56,924,989.40** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 163,546,637.96 | 56,924,989.40 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,386.10 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **8,014,589,100.00** | **9,130,424,254.59** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **2,030,512,300.00** | **3,321,479,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,030,512,300.00 | 3,321,479,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0.00** | **4,572,293.59** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 4,572,293.59 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **5,672,680,600.00** | **5,237,839,261.00** |
| 133002 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,672,680,600.00 | 5,237,839,261.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **311,396,200.00** | **566,532,900.00** |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 305,597,200.00 | 566,532,900.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 5,799,000.00 | 0.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **27,148,559,703.35** | **29,713,598,707.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **27,148,559,703.35** | **29,713,598,707.13** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **303,533,464.90** | **454,752,547.06** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **210,980,255.54** | **323,815,386.66** |
| 210101 | Үндсэн цалин | 134,996,818.09 | 199,930,109.39 |
| 210102 | Нэмэгдэл | 43,127,744.45 | 70,684,275.09 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,540,000.00 | 20,113,098.44 |
| 210104 | Урамшуулал | 16,315,693.00 | 33,087,903.74 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **27,289,537.36** | **39,667,320.92** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,879,470.49 | 27,164,576.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,108,816.64 | 3,195,832.55 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,680,333.31 | 2,556,665.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 420,083.33 | 611,153.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,200,833.59 | 6,139,092.45 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **46,468,897.00** | **46,769,881.38** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,289,993.00 | 3,074,097.38 |
| 210302 | Түлш, халаалт | 42,922,524.00 | 41,845,792.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,256,380.00 | 1,849,992.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,867,645.00** | **27,824,259.10** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,870,100.00 | 6,518,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,559,000.00 | 1,887,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,255,000.00 | 2,247,608.10 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 170,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,003,545.00 | 17,001,651.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,871,000.00** | **8,119,200.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 924,000.00 | 1,121,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 947,000.00 | 6,998,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **438,000.00** | **3,402,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 438,000.00 | 3,402,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,668,130.00** | **4,229,499.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,800,000.00 | 2,379,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 797,100.00 | 797,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 65,300.00 | 99,882.00 |
| 210807 | Газрын төлбөр | 0.00 | 24,957.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,005,730.00 | 928,060.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **950,000.00** | **925,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 950,000.00 | 925,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **26,845,026,238.45** | **29,258,846,160.07** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **19,435,172,681.80** | **22,746,208,983.36** |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 19,293,999,137.00 | 22,693,061,527.35 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,975,000.00 | 3,163,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 137,198,544.80 | 37,946,156.01 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 12,038,300.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **7,409,853,556.65** | **6,512,637,176.71** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,409,853,556.65 | 6,512,637,176.71 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **-1,565,835,508.68** | **606,607,074.64** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-1,565,835,508.68** | **606,607,074.64** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 4,176,630,185.17 | 2,610,794,676.49 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,610,794,676.49 | 3,217,401,751.13 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **25,136,678,200.00** | **23,158,443,080.82** | **1,981,078,057.18** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **25,136,678,200.00** | **23,158,443,080.82** | **1,981,078,057.18** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **551,253,200.00** | **450,180,253.47** | **103,915,884.53** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **397,889,300.00** | **319,743,381.66** | **78,145,918.34** |
| 210101 | Үндсэн цалин | 221,619,600.00 | 200,213,953.14 | 21,405,646.86 |
| 210102 | Нэмэгдэл | 108,623,200.00 | 66,612,270.09 | 42,010,929.91 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,468,200.00 | 20,113,098.44 | 6,355,101.56 |
| 210104 | Урамшуулал | 41,178,300.00 | 32,804,059.99 | 8,374,240.01 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **49,548,800.00** | **39,167,032.33** | **10,381,767.67** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,693,100.00 | 26,818,456.31 | 6,874,643.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,964,000.00 | 3,155,112.51 | 808,887.49 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,171,200.00 | 2,524,089.41 | 647,110.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 792,800.00 | 603,801.75 | 188,998.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,927,700.00 | 6,065,572.35 | 1,862,127.65 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **52,963,100.00** | **46,769,881.38** | **6,193,218.62** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,909,400.00 | 3,074,097.38 | 1,835,302.62 |
| 210302 | Түлш, халаалт | 46,116,000.00 | 41,845,792.00 | 4,270,208.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,937,700.00 | 1,849,992.00 | 87,708.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,872,700.00** | **27,824,259.10** | **1,048,440.90** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,573,700.00 | 6,518,000.00 | 55,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,779,000.00 | 1,887,000.00 | 892,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,255,000.00 | 2,247,608.10 | 7,391.90 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 190,000.00 | 170,000.00 | 20,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,075,000.00 | 17,001,651.00 | 73,349.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,405,400.00** | **8,119,200.00** | **286,200.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,405,400.00 | 1,121,000.00 | 284,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,000,000.00 | 6,998,200.00 | 1,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **7,925,900.00** | **3,402,000.00** | **4,523,900.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,925,900.00 | 3,402,000.00 | 4,523,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,698,000.00** | **4,229,499.00** | **3,336,439.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,550,000.00 | 2,379,500.00 | 2,379,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 800,000.00 | 797,100.00 | 797,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 100,000.00 | 99,882.00 | 99,882.00 |
| 210807 | Газрын төлбөр | 50,000.00 | 24,957.00 | 24,957.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,198,000.00 | 928,060.00 | 35,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **950,000.00** | **925,000.00** | **25,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 950,000.00 | 925,000.00 | 25,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **24,585,425,000.00** | **22,708,262,827.35** | **1,877,162,172.65** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **24,585,425,000.00** | **22,708,262,827.35** | **1,877,162,172.65** |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 24,569,089,700.00 | 22,693,061,527.35 | 1,876,028,172.65 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,297,000.00 | 3,163,000.00 | 1,134,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,038,300.00 | 12,038,300.00 | 0.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **25,136,678,200.00** | **21,107,316,957.33** | **566,532,900.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **3,321,479,800.00** | **3,321,479,800.00** | **0.00** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,321,479,800.00 | 3,321,479,800.00 | 0.00 |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **21,815,198,400.00** | **17,775,561,764.57** | **4,039,636,635.43** |
| 330001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 21,815,198,400.00 | 17,775,561,764.57 | 4,039,636,635.43 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **0.00** | **10,275,392.76** | **10,275,392.76** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 10,275,392.76 | 10,275,392.77 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 2,610,794,676.49 | 2,610,794,676.50 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 3,217,401,751.13 | 3,217,401,751.14 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **35.00** | **29.00** | **0.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** | **0.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 0.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 0.00 | 0.00 | 0.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **17.00** | **14.00** | **0.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 0.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 9.00 | 0.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 4.00 | 0.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,572,293.59** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,572,293.59** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,572,293.59** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **4,072,005.00** |
| 210102 | Нэмэгдэл | 4,072,005.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **500,288.59** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 346,120.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 40,720.04 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 32,576.04 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,352.01 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 73,520.10 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **4,572,293.59** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **4,572,293.59** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,572,293.59 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,572,293.59** |

Аудитаар нийт 203,084.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил[1] илэрснээс завсрын аудитаар 33,585.4 мянган төгрөгийн алдааг залруулсан байна. Нийт 169,499.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд 1,655.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 148,288.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 19,555.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

**Завсрын аудитын талаар**

2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 33,585.4 мянган төгрөгийн 9 алдааг илрүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах тухай зөвлөмж хүргүүлсэн болно. Үүнд:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан 767.0 мянган төгрөгийн бараа материалыг тодруулга тайланд тусгасан боловч Санхүүгийн үр дүнгийн тайланд орлогын ангиллыг буруу тайлагнасан
- Тайлант хугацаанд бараа материалын тодруулгын тайлан болон нярвын бараа материалын тайлангийн орлого зардалд горим сорил хэрэгжүүлэхэд нярвын тайланд орлогыг 2,467.0 мянга, зарлагыг 3,171.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нийт 5,638.4 мянган төгрөгийн алдаа илэрсэн
- Үндсэн хөрөнгийн тодруулгын тайлан болон нярвын үндсэн хөрөнгийн тайланд тулгалт хийхэд МХГ-аас шилжүүлэн өгсөн 2,091.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг нярвын тайланд бүртгэж тайлагнаагүй
- ХХОАТ-ын тайланд албан хаагчдын цалинг 6,055.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- НДШ-ийн тайланд албан хаагчдын цалинг 1,485.5 мянган төгрөгийг илүү тайлагнасан
- Цалингийн зардлыг 12,774.3 мянган төгрөгөөр бууруулж дансны бичилт хийсэн
- Үр дүнгийн урамшууллыг бодитой үндэслэлтэй тооцоогүй, улирлын дундуур ажилд орсон албан хаагчид үр дүнгийн урамшууллыг 140.4 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Урсгал завсар болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 3,950.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлснийг мэдээлээгүй
- Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу 682.5 мянган төгрөгөөр түлш халаалтын өр төлбөрийг барагдуулсан

Завсрын аудитаар өгсөн залруулгын биелэлтийг 2024.03.11-ны №121 тоот албан бичгээр ирүүлсэн бөгөөд залруулгыг бүрэн хийсэн байна.

## 5.1 Төлбөрийн акт

**5.1.1** Нягтлан бодогч нарын ажлыг улирал бүр дүгнэж, ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч П.Гантуяа, Ө.Сайнхүү нарт 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар “өөрчлөлтгүй” дүгнэлт авсан гэх

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үндэслэлээр 1,655.6 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.6, 7.1.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1,Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4,Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2, Сангийн сайдын 2022 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 25 дахь хэсгийг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Давхардуулж олгосон урамшууллыг орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 **Албан шаардлага**

**5.2.1** Зардлын ангилал зөрчиж, бичиг хэргийн зардлаас 1,850.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг тус тус зөрчсөн

**Шийдвэрлэсэн нь**: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**5.2.2** Тайлант онд худалдан авсан 1,850.0 мянган төгрөгийн 2 принтер худалдан авёан боловч үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 16.5.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх заалтыг тус тус зөрчсөн

**Шийдвэрлэсэн нь**: Худалдан авсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

**5.2.3** Бичгийн хэргийн материалын зардлаас 11, 12-р сард их хэмжээний бичгийн цаас, бал, принтерийн хорыг худалдан авч шаардах хуудсаар тавьж олгосон нь бодит хэрэгцээ шаардлагатай нийцээгүй.

Энэ нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:**Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

**5.2.4** Ниймгийн даатгалын сангийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, нийт 134,540.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Үүнд:

- Төлбөртэй үйлчилгээний авлага-43,659.5 мянган төгрөг
- Байгууллагаас авах авлага-19,744.7 мянган төгрөг
- Бараа үйлчилгээний зардлын өглөг-34,912.1 мянган төгрөг
- Урьдчилж орсон орлого-36,223.9 мянган төгрөг

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь**: Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, бодит авлага, өглөгийг данс бүртгэлд тусгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

**5.2.5** Нийгмийн даатгалын сангийн түр дансанд төвлөрсөн орлогоос санхүүгийн тайланд тусгагдаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй 7,974.0 мянган төгрөгийн өр төлбөрийг шилжүүлж, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, НББ тайлагналд өмнөх үеийн үр дүн дансанд бичилт хийж, цэвэр хөрөнгө, эздийн өмчийн тайланд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансыг үндэслэлгүйгээр бууруулж буруу илэрхийлсэн

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.6, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь**: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, НББ-ийг үнэн зөв хөтлөх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бүртгэлтэй холбоотой асуудал

1.1. *Илрүүлэлт:*

Байгууллагын эзэмшлийн 1 газрыг данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4.2, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Газрыг үнэлгээ хийлгэж үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх

2. Хууль, тогтоомжтой холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу тайлант оны эхэнд албан хаагчдын ээлжийн амралтын хуваарь баталсан тушаал гаргаагүй, хэн, хэзээ, ямар хугацаанд ээлжийн амралтаа эдлэх нь тодорхойгүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтын 1.2 дахь заалтуудыг зөрчсөн.

*Өгсөн зөвлөмж:* Ээлжийн амралтын хуваарийг батлах

3. Төрийн хэмнэлттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Цалингийн хэмнэлтээс албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгохдоо "Засгийн газрын 2023 оны 52 дугаар тэмдэглэлд ажлын үр дүнг харгалзан олгоно" гэсэн чиглэлийг баримтлаагүйгээс тайлант онд ажилласан хугацааны ажлын үр дүнгээр урамшууллыг тооцож олгоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.1.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6, Засгийн газрын 2023 оны 52 дугаар хуралдааны тэмдэглэлийн заалтыг тус тус зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг олгохдоо ажлын үр дүнг тооцож олгох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс | 9 | 33.6 | 5 | 16.0 | 4 | 17.5 | 6 | 86.2 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 9 | 33.6 | 5 | 16.0 | 4 | 17.5 | 6 | 86.2 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

**/сая төгрөгөөр/**

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс | 9 | 147.9 | 1 | 1.7 | 7 | 146.2 | 1 | - | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 9 | 147.9 | 1 | 1.7 | 7 | 146.2 | 1 | - | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс | 1 | 18.9 | | | | | 1 | 18.9 |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 18.9 | | | | | 1 | 18.9 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Говьсүмбэр аймгийн Нийгмийн | 3 | 2.7 | | | 1 | 2.1 | 1 | 0.7 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| даатгалын хэлтэс | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | 3 | 2.7 | | | 1 | 2.1 | 1 | 0.7 |
| Нийт дүн | 4 | 21.7 | | | 1 | 2.1 | 3 | 19.6 |